



СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№87 /300/

2022.05.05

Цаг үе, үйл явдал

МОНГОЛ БИЧГИЙН УРАЛДААНД 80 ГАРУЙ АЛБА ХААГЧИД ОРОЛЦОЖ БАЙНА

Батлан хамгаалахын сайдын тушаалаар Монголын ард түмний оюуны соёлын нандин өв болсон Монгол бичгээр хадгалан хамгаалж, сурч эзэмших, түгээн дэлгэрүүлэх идэвхийг өрнүүлэх, бүх нийтийг сургах, монгол бичгийн хэрэглэх орчныг бий болгох зорилгоор монгол бичгийн уралдааныг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний офицер ахлагч, ажилтан алба хаагч багш, судлаач, оюутан сонсогч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын дунд өнөөдөр зохион байгуулж байна.

Уралдаанд Зэвсэгт хүчний нэгтгэл анги, байгууллагын 80 гаруй алба хаагчид оролцож байгаа бөгөөд уралдаан алдаагүй зөв бичих, таталган бичгийг алдаагүй зөв унших, цэвэр сайхан бичих, уран бичлэг, компьютерт эх бичвэрийг монгол бичгээр шивэх гэсэн 5 төрлөөр өрсөлдөнө. Хоёр өдөр үргэлжлэх дээрх уралдаан төрөл тус бүр шилдэг 3 орлогчийг шалгаруулж, шилдгүүдийн шагналын 5 дугаар сарын 9-ны өдөр Батлан хамгаалах яаманд гардуулан өгөх юм.

Ташрамд, Монгол хэлний тухай хуульд "2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжих бэлтгэлийг бүрэн хангахад оршино" хэмээн заасны хүрээнд Батлан хамгаалахын сайдын тушаалаар Зэвсэгт хүчний 21 нэгтгэл ангийн 26 алба хаагчийг хамруулсан үндэсний бичгийн сургагч багшийн дамжаа 45 хонгийн хугацаатай явагдаж байгаа бөгөөд тус дамжааны 8 суралцагч дээрх уралдаанд оролцож байгаа юм.



“ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ” СЭДВИЙН ХҮРЭЭНД СУРГАЛТАД ХАМРАГДАВ



БХЯ-ны бие бүрэлдэхүүн өнөөдрийн мэдээллийн цагийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтраг зохион байгууллаа. Энэ хүрээнд Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн Ж.Азжаргал, мэргэжилтэн З.Ишханд нар “Хүүхэд хамгааллын бодлого, хэрэгжүүлэх арга зам” сэдвийн хүрээнд лекц уншиж, хүүхдийн эрхийг хангах, хамгаалах төр иргэн, хуулийн этгээдүүдийн үүрэг оролцоо, хамтын ажиллагааны талаар яриа таниулга хийсэн юм.

Тус сургалт нь “Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн чуулган”-ыг угтан авч хэрэгжүүлж буй ажлуудын нэг хэсэг бөгөөд хэд хонгийн өмнө Батлан хамгаалах яамнаас тус салбарын хэмжээнд хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын асуудлаар ээлжит хэлэлцүүлгийг зохион байгуулсан юм.

Цаашид салбарын Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3т заасны дагуу хүүхэд хамгааллын бодлого боловсруулж, байгууллагын дэргэдэх эцэг, эхийн зөвлөлөөр дамжуулан хүүхдэд ээлтэй байгууллага бий болгоход анхаарч ажиллахаа удаа дараа илэрхийлж буй юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
7	-6

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	19

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,100.00	3,110.0
EUR	3,332.0	3,360.0
CNY	471.00	473.00
RUB	39.70	40.00
JPY	24.00	24.80
KRW	2.47	2.49

ЗУРХАЙ

2022.05.05 /ПҮРЭВ ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 4

ЗУНЫ ТЭРГҮҮН ХӨХӨГЧИН МОГОЙ САРЫН ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ШАР МОРЬ ӨДӨР

Үс ЗАСУУЛБАЛ:

Бие эрхтний хүч сайжирна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.28-20.10

Барилдлага:

Үл зохилдох

Шүтэн барилдлага:

САНСАР

Суудал: Төмөр

Энэ өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба сүм дуганыг сэргээх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, гэр бүрэхэд сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, гөлөг тэжээхэд муу.

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогосод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Модон хохимой өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал бие эрхтний, хүч сайжирна.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН

2,273,004 /69.9%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН

2,175,662 /66.9%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН

1,040,412 32,0%

125,447 /3,9%/

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

8475 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

15

ЭДГЭРСЭН

8339

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 515,354,689

Эдгэрсэн

Нийт: 470,075,418

Нас барсан

Нийт: 6,269,587

БАГА НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ ТА БҮХЭН ХҮҮХЭДЭЭ ЭРТ ИЛРҮҮЛЭГТ ХАМГААЛАГАЙ!

6-17 НАС

ӨСӨЛТ АЖИЛТИТ ҮЗЭГТ АМАНЫ ХАВДИЙН ЭРҮҮЛ МЭНД

СЭТГЭЭ, ЗАН ТӨРХИЙ АЖИЛТИТ СУРЬСЭЙН ИЛРҮҮЛЭГ

ЭМЧИЙН ҮЗЭГТ БИЭНИЙ ХЭМЖИЛТ, БИЭНИЙ НИЙГЭЙН ИЛДЭС

ШҮД ЦОРОЛ ШҮДНИЙ ГАН ХАВЧИЛ ШҮД УГААХ АРГАЧЛАЛ ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВЛӨГӨӨ

Эрүүл мэндийн газар, Үндэсний эрүүл мэндийн газар, Үндэсний хүүхдийн эрүүл мэндийн газар, Үндэсний хүүхдийн хамгааллын газар

Цахим шууданд

“МУЗЕЙН ХҮЧ НӨЛӨӨ ЦЭРГИЙН АЛБАНД ТАНИН МЭДЭХҮЙН АЯЛАЛ”-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний 015 дугаар анги

Жил бүр Монгол цэргийн музейгээс уламжлал болгон зохион байгуулдаг “Музейн хүч нөлөө цэргийн албанд танин мэдэхүйн аялал”-ыг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2022 оны А/222 дугаар тушаалаар энэ сарын 4-ны өдөр Цэргийн гавьяаны улаан тугийн одонт, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн хурандаа О.Сардарийн нэрэмжит Зэвсэгт хүчний 015 дугаар анги дээр амжилттай зохион байгууллаа.

Энэхүү аяллын хүрээнд дэд хурандаа Л.Гантөмөрөөр ахлуулсан Соёлын өвийн

үндэсний төв, Чингис хааны музей, Монголын үндэсний музей, Богд хааны музей, Чойжин ламын музей, Театрын музей, Дүрслэх урлагийн музей, Олон улсын музейн зөвлөлийн Монголын хороо, Улаанбаатар хотын музей, Уран зургийн галерей, Монгол цэргийн музейн нийт 30 хүний бүрэлдэхүүнтэй музейн холбооны гишүүд цэргийн анги салбартай танилцаж, цэргийн аж амьдрал, ахуйтай танилцлаа.

Эдгээр гишүүдэд иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх ажлын хүрээнд ангийн түүхэн замнал, Алдарын тасалгаа, дотоод үйл ажиллагаа сурталчилсны

зэрэгцээ зэвсгийн үзэсгэлэн, бүтээн байгуулалтын ажлаа үзүүлж, цэргийн албан хаагч нарын цэрэг нормын хоол амтлуулсан нь таалагдсан тухай талархлаа илэрхийлж байсан бөгөөд зарим нэгэн хүмүүсийн амнаас ийм сайхан эр цэргийн албанд үр хүүхдээ явуулна гэх үг чихэнд сонсогдож байлаа.

Үүний дараагаар тэд өөрийн байгууллагын үйл ажиллагааны талаар ангийн нийт бие бүрэлдэхүүнд яриа таниулга хийж, ангийн номын фондод музейн холбогдолтой ном, материалуудыг бэлгэллээ.

Ахлагч Б.ЗОЛЗАЯА

ТАМИРЧИН ДАЙЧДАА ЗОРЬЖ ИРСЭН АВЬЯАСЛАГ ЗАЛУУСЫН ТОГЛОЛТ

Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын 1500 гаруй тамирчин дайчин Зэвсэгт хүчний 2022 оны аварга шалгаруулах “Марш-тусгай бэлтгэлийн цогцолбор” тэмцээнд оролцохоор Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд бэлтгэлдээ гараад байна.

Цэргийнхний “олимп” хэмээгдэх энэхүү тэмцээнд дайчид амжилттай оролцохоор өдөр, шөнөгүй бэлтгэлдээ шамдан байгаа энэ цаг үед Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн авьяаслаг алба хаагчид Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн бүрэлдэхүүн тэр дундаа хугацаат албаны дайчдын сэтгэл санааг өргөж урам зориг өгөх, албаараа бахархах үзлийг нэмэгдүүлэх зорилгоор урлагийн тоглолтыг зөвлөлийн байрлалд нь очиж толилуулав. “Аргамаг хүлгийн хурдаар” морин хуурын гоцлолыг дэслэгч Б.Баттулга, “Аялгуу” эвэр бүрээний гоцлолыг байлдагч Г.Ганболд нар эгшиглүүлж, “Сайн байна уу, ээжээ”-г ахлах байлдагч Э.Содболд, байлдагч Н.Шинэбаяр, “Марш тактик”-ийг түрүүч н.Энхбаярсгалан,



байлдагч Г.Золбоот нар дуулж, дэд түрүүч Ш.Өлзийбуян өөрийн зохиосон “Тусгай салбарынхан” шүлгээрээ нөхдөдөө “бэлэг” барьж, алга ташилт дунд дуулж, хуурдаж, бүжиглэсэн юм.

Энэ үеэр Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлалын мэндчилгээг Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн ахлах ахлагч Ш.Даваацэрэн “Онжавууд” дуугаараа, Агаарын цэргийн

командлалын мэндчилгээг Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн ахмад П.Бэхбат хөгжмийн аялгуугаар хүргэсэн нь дайчдын сэтгэлд ихэд нийцэв.

Төлөвлөгөө ёсоор 5 дугаар сарын 7-ны өдөр Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн авьяаслаг алба хаагчдын бүрэлдэхүүн мөн адил хээрийн байрлалд очиж, дайчдад тоглолтоо өргөн барина.

Ахлах дэслэгч Д.БОЛОР



МАРШИД ОРЖ БУЙ НУТГИЙН ЦЭРГҮҮДДЭЭ АМЖИЛТ ХҮСЛЭЭ



Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Цэргийн Штаб

Сэлэнгэ аймгаас 2021 оны 2 дугаар ээлжээр татагдаж Зэвсэгт хүчний 119 дүгээр ангид хугацаат цэргийн албаа нэр төртэй хаахын зэрэгцээ цэргийнхний “олимп” гэгдэх Зэвсэгт хүчний аварга шалгаруулах “Марш тактик

тусгай бэлтгэлийн аварга” шалгаруулах тэмцээнд оролцож буй дайчдаа эргэлээ.

Тодруулбал, тус аймгийн Цэргийн штабаас дайчилгааны офицер дэд хурандаа Б.Мөнгөнцож, жолооч н.Бат-Эрдэнэ нар очиж уулзан тэдний албанд нь болон тэмцээн уралдаанд

нь амжилт хүслээ. Энэ үеэр хугацаат цэргийн алба хааж дайчидтай нутаг орны сонин хачин, хаваржилт болон цаг үеийн бусад асуудлаар ярилцаж аймгийн удирдлагын баг хамт олны мэндчилгээг уламжилж удахгүй намар халагдаад орон нутагтаа ирэхэд нь баяртайгаар уулзахын ерөөл тавилаа.

БЯЦХАН ОХИНД ДАВЫНХ НЬ ОНЖАВУУД ТУСЛАМЖИЙН ГАРАА СУНГАЛАА



Бяцхан охин У.Маргадад түүний аав дэд хурандаа Б.Ууганбаярын онжавууд буюу 2001 оны Ерөнхий цэргийн А курсийн хамт төгсөгчид хандивын гараа сунгалаа. Тэд “Бид цэргийн нөхөрлөлөөр аливаа гэтлэн давж чаддаг, нэгнээ хурцлан ирлэдэг, урам өгдөг, дэмжин тэтгэдэг, түшин тулдаг хүмүүс. Энэ нөхөрлөл нэгийнхээ амьдралынхаа хүнд хэцүү үе, баяр баяслыг хуваалцдаг болгож, эх орны тусгаар тогтнол хэмээх эрхэм зүйлд нэгдүүлж чаддагаараа бусдаас ялгаатай. Бидний нэгнийх нь бяцхан охин өвдөхөд хүртэл сэтгэл өвдөөд, бушуухан эдгээх тухай бодож явлаа. Олны хүч оломгүй далай гэдэг шиг их, бага гэлтгүй сэтгэлийн хандив илгээж байгаа сайхан сэтгэлт мөрдэс нэгтнүүд болон түмэн олондоо гүн талархал илэрхийлье. Одоо эмчилгээний үлдсэн

хувиа богино хугацаанд бүрдүүлэх шаардлага байна” хэмээгээд 8 сая 500 мянган төгрөгийг гардуулан өгөв. Мөн тэд Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийнх нь хамт олон сайн үйлсийн аянд өөрсдийн санаачилгаар идэвхтэй оролцсоныг онцлон тэмдэглэж, бяцхан охинд хандивын тусламжаа илгээхийг олон нийтээс хуссан юм. Мөн энэ өдөр хурандаа Г.Ялалт даргатай нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын хамт олон 900 мянган төгрөг, 2007 онд БХУА хамт төгссөн офицерууд 1 сая 550 мянган төгрөг, Зэвсэгт хүчний 234 дүгээр анги 1 сая 270 мянган төгрөг, Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар 400 мянган төгрөг, Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал унтраах, аврах 18 дугаар анги 130 мянган төгрөг, Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газар 395 мянган төгрөг, энхийг

сахиулах ажиллагаанд оролцсон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны залуучууд 1 сая 740 мянган төгрөгийг тус тус хандивлаж, бяцхан охиныг хурдан эдгэхийг ерөөлөө. Үрийнхээ төлөө тэмцэж яваа дэд хурандаа Б.Ууганбаяр, ахлагч С.Ганзаяа нарт эрхэм та туслаарай. Тус хэзээ ч багаддаггүй юм шүү. Бяцхан охин нь тархины үрэвсэл өвчнөөр оношлогдож, БНСУ-д 450 сая төгрөгийн хагалгаанд яаралтай орох болсны дагуу аав, ээж нь болоод ЗХЖШ, ОБЕГ, Төрлийн цэргийн командлалууд хандивын аян өрнүүлж, сайхан сэтгэлт ард түмэн, мөрдэс нэгт нөхдөөсөө тусламжийн гараа сунгахыг уриалсаар байна.

ХАНДИВЫН ДАНС
ХААН БАНК: 5073035840
ГОЛОМТ БАНК: 4305125348
Данс эзэмшигч:
Ээж-Сэргэлэн
Ганзаяа Харилцах утас
С.Ганзаяа 88376062

